


ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН БҮРЭНХИЙ ЗАХИРАЛ



УЛААНБААТАР ХОТ

“ХӨХ АРСЛАН” ХХК-НЫ  
ЗАХИРАЛ

С. ГАНТУЛГА  
УХН922/2789507

## ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ГЭРЭЭ

2019 оны 01 сарын 21-ны өдөр

№

Улаанбаатар хот

2019 01 25 16 1  
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол улсын иргэний хууль, гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, хувь хүний нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “Үйлчлүүлэгч” гэх), түүнийг төлөөлж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Аж ахуйн менежер Ч.Тунгалаг, нөгөө талаас Улсын бүртгэлийн 9011172148 тоот гэрчилгээтэй, 2789507 тоот регистертэй, УБ хотын Цагдаагийн газрын 2018070000022 тоот бүртгэлтэй “Хөх Арслан” ХХК (цаашид “хамгаалагч” тал гэх)--ийг төлөөлж Харуул хамгаалалтын албаны дарга У.Нямдалай нар (цаашид хамтад “Талууд”, тус тусад нь “Тал” гэх)-ийн хооронд доорхи нөхцлийг тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Хамгаалагч талын зүгээс үйлчлүүлэгч талын оффисын барилга байгууламж, гадна талбайд гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ.
- 1.3. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд тус объектийн аюулгүй байдлыг хангаж үйлчилгээ харилцааны соёлыг эрхэмлэн ажиллахад оршино.
- 1.4. Хоёр тал бие биенийхээ хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэн, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, үйл ажиллагаандаа хуулиа дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, албаны нууцыг чанд сахих зарчмыг баримтална.

## ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээний үйлчлэх хугацаа: 2019.01.01--2019.12.31
- 2.2. Хугацааг тоолохдоо гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

## ГУРАВ.ГЭРЭЭНИЙ ҮНЭ, АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 3.1. Талуудын харилцан тохиролцсоноор үйлчлүүлэгч талын объектод харуул хамгаалалтын гурван ажилтан гурван ээлжээр ажиллах бөгөөд хамгаалалтын үйлчилгээний төлбөр 1 сард нийт 2,200,000 төгрөг байхаар тохиролцов.
- 3.2. Оролцогч талууд гэрээний биелэлтийг улирал тутам дүгнэж гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчлан тохиролцож байна.
- 3.3. Үйлчлүүлэгч тал нь харуул хамгаалалтын үйлчилгээний хөлсийг сар бүрийн 30-ний дотор дансаар саадгүй төлнө.

- 3.4. Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг улирал тутам дүгнэн хэлэлцэж цаашид ажиллах чиглэлээ тодорхойлон ажиллана. Оролцогч аль нэг тал нь гэрээг цуцлахыг хүсвэл 30 хоногоос доошгүй хугацааны өмнө нөгөө талд албан ёсоор асуудлаа бичгээр мэдэгдсэний үндсэн дээр зохих шийдвэрийг хамтран гаргана.
- 3.5. Суурь үнэ нэмэгдэх болон хасагдах, инфляци өсөх, буурах нөхцөлд албан бичгээр харилцан тохиролцон үйлчилгээний үнэнд өөрчлөлт оруулан шийдвэрлэж болно.
- 3.6. Хамгаалалтын ажилтны эрх, үүргийг хамгаалагч талын ажилтантай байгуулсан гэрээгээр зохицуулна. Талууд хамгаалалтын ажилтнаар энэхүү гэрээнд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

### **ДӨРӨВ. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ**

- 4.1. Хамгаалагч нь гэрээний зүйлийг шалган актаар баталгаажуулан хүлээн авна. Уг акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

### **ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1. Үйлчлүүлэгч талын эрх, үүрэг:

- 5.1.1. Харуул хамгаалалттай холбогдсон асуудлаар өөрийн ажилтнууд болон хамгаалагч тал /хамгаалалтын ажилтан/-д хууль ёсны шаардлага тавих.
- 5.1.2. Хамгаалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа тохиолдолд зохих шаардлага тавьж, эсвэл энэхүү гэрээний 3.4-д заасны дагуу гэрээг цуцлах талаар санал тавих.
- 5.1.3. Хамгаалалтын ажилтанд объект болон ажил үүргийг нь танилцуулах заавар зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үнэлэлт өгөх.
- 5.1.4. Харуул хамгаалалтын алба хаагчийн гүйцэтгэх үүргийг сайтар танилцуулж заавар зөвлөмжөөр хангах, шаардлагатай бол зохих баталгаа гаргуулах өөрийн байгууллагад гарсан өөрчлөлт хөдөлгөөнийг цаг тухайд нь мэдэгдэж байх.
- 5.1.5. Хамгаалагч тал /хамгаалалтын ажилтан/-ын зүгээс гэмт халдлага, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх талаар тавьсан хууль ёсны санал, шаардлагыг тухай бүр нь авч шийдвэрлэх.
- 5.1.6. Хамгаалалтын ажилтныг ажиллах нөхцөл /ажлын өрөө, бичиг баримт болон бүртгэлийн дэвтэрүүд хадгалах сейф бусад шаардлагатай зүйл/-өөр хангах.
- 5.1.7. Өөрийн объектод нэвтрэн орох, гарах журмыг тогтоож албан ёсны шийдвэр гаргаж мөрдүүлсэн байх.
- 5.1.8. Хамгаалуулах объектийг акт үйлдэн хүлээлгэж өгч баталгаажуулж гарын үсэг зурна.
- 5.1.9. Цаашид шийдвэрлэвэл зохих арга хэмжээг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 5.1.10. Хамгаалалтын ажилтанг албан үүрэгтэй нь холбогдуулж шагнаж урамшуулж болно. Энэ тохиолдолд хамгаалагч талд урьдчилан мэдэгдэнэ.

- 5.1.11. Хамгаалалтын ажилтан албан үүргээ гүйцэтгэж яваад амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийн хувьд хохирсон, гэмтэж бэртсэн тохиолдолд материаллаг дэмжлэг туслалцаа, тусламж үзүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжын хүрээнд шийдвэрлэнэ.
- 5.1.12. Энэхүү гэрээний 3.1-р зүйлд заасан хамгаалалт үйлчилгээний сарын төлбөрийг тухайн сарын 30-ны дотор хамгаалагч талд саадгүй шилжүүлж байна. Энэ хугацаанаас төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 1%-ын алдангийг хамгаалагч талд төлнө.

## 5.2. Хамгаалагч талын эрх, үүрэг:

- 5.2.1. Үйлчлүүлэгч байгууллагын талаар шаардлагатай мэдээлэл авах, хамгаалж буй объект, түүний онцлог, хамгаалалтыг зохион байгуулах талаар харилцан мэдээлэл солилцож ажиллах
- 5.2.2. Хамгаалах эд хөрөнгө, объект нь гэрээнд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах, гэмт халдлага, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг зөрчлийг таслан зогсоох.
- 5.2.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн объектийг хамгаалалтын үйлчилгээгээр хангах.
- 5.2.4. Харуул хамгаалалтын алба хаагч нь объектын гадна талбайн 50м доторх, орчны эмх цэгц, аюулгүй байдлыг хангах үүднээс гадна цэвэрлэгээг хариуцан ажиллана.
- 5.2.5. Хамгаалалтын нөхцөлийг сайжруулах гэмт халдлага, болзошгүй аюул хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар санал, шаардлагыг үйлчлүүлэгч талд тавьж биелэлтийг хангуулах
- 5.2.6. Хамгаалалтын ажилтныг албан ёсоор томилж, тэдэнд гэрээнд заасан ажил, үүргийг танилцуулж, мэргэжлийн удирдлагаар хангах.
- 5.2.7. Хамгаалалт үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, гомдол шаардлагыг тухай бүр нь хүлээн шийдвэрлэн хариу өгөх
- 5.2.8. Хамгаалалтын ажилтнуудыг сургалт /эрх зүй, бие хамгаалах, хүн нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх/ ын тусгай төлөвлөгөө хуваарийн дагуу албаны сургалтанд хамруулах
- 5.2.9. Хамгаалалтын ажилтныг дүрэмт хувцас, хүн нэг бүрийн тусгай хэрэгсэл болон бусад шаардлагатай хэрэгсэлээр хангах.
- 5.2.10. ХХАХаагчдын үүргийн биелэлтэнд байнга хяналт тавьж ажиллан гарсан дутагдалыг тухай бүр шийдвэрлэж ажиллах.
- 5.2.11. Хамгаалалтын ажилтанд тогтоосон цалин хөлсийг цаг хугацаанд нь олгож байх.
- 5.2.12. Ажилтантай байгуулсан гэрээний дагуу хариуцлага, сахилга, ажлын үр дүнг харгалзан гэрээг дүгнэж, цаашид ажиллуулах эсэхийг үйлчлүүлэгч талын санал үнэлгээг харгалзан шийдвэрлэж байх.
- 5.2.13. Хамгаалж буй объектонд халдах, амь нас, эрүүл мэндэд илт хохирол учирч болохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэмэгдэл хүчний туслалцаа үзүүлэх.
- 5.2.14. Хамгаалах объектийг акт үйлдэн хүлээж авах
- 5.2.15. ХХАХаагч нь гэрээт харуул хамгаалалтын тухай хуулинд заагдсан эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллана.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.2.1 Хамгаалалтын ажилтны хууль бус, илт буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарсан сөрөг үр дагаврыг шийдвэрлэх, арилгах, хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон үйлчлүүлэгч талд учирсан бодит хохиролыг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ гаргуулан хохиролыг барагдуулах

### **ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**


- 9.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 9.2. Хэрэв маргаанаа зөвшилцөх аргаар шийдвэрлэж боломжгүйд тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **НАЙМ. БУСАД ЗҮЙЛ**

- 10.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 10.2. Гэрээ нь талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 10.3. Аль нэг талын хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.4. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 10.5. Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.


### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

  
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн  
Аж ахуйн менежер

Ч.Тунгалаг  
Утас 99062485

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

  
"ХӨХ АРСЛАН" ХХК-ны Харуул  
хамгаалалтын албаны дарга  
У.Нямдалай